



МОНГОЛ УЛС  
СҮХБААТАР АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГА

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг,  
Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг, 22075  
Утас, факс: 70518232  
Цахим шуудан: info@sukhbaatar.gov.mn

2025.01.08 № 02/15

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАРТ

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол шийдвэрлэх тухай хууль, Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоолын дагуу иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлын 2024 оны жилийн эцсийн тайлан мэдээг нэгтгэн хүргүүлэв.


Хавсралт 9 хуудастай.

ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ



Б.БАТБААТАР

2225080006



٢٠١٦/٥/١٤  
٢٠١٦/٥/١٤  
٢٠١٦/٥/١٤

[illegible][illegible]



СҮХБААТАР АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 01 сарын 06 өдөр

Дугаар 01

Баруун-Урт сум

Аймгийн Засаг даргын Зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдааны 01 тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН нь: Иргэдээс төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдол, санал хүсэлтийн жилийн эцсийн тайланг хэлэлцүүлэх тухай.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Иргэдээс төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдол, санал хүсэлтийн жилийн эцсийн тайланг хэлэлцүүлэх явцад Засаг даргын Зөвлөлийн гишүүдээс гарсан саналыг тусгаж тайланг хугацаанд нь Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлэхийг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Б.Амарзаяа, мэргэжилтэн Б.Бямбасүрэн нарт үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2225030002

## ТАНИЛЦУУЛГА

Иргэдээс Сүхбаатар аймгийн төрийн захиргааны байгууллага,  
албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл  
гомдлын шийдвэрлэлтийн тухай

(2024 оны жилийн эцсийн байдлаар)

"Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол шийдвэрлэх тухай" хууль, Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2007 оны 08 тоот албан даалгаврын дагуу аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудаас 2024 оны жилийн эцсийн байдлаар ирүүлсэн иргэдийн өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн тайланг нэгтгэн танилцуулж байна.

Тайлант хугацаанд аймгийн нийт төрийн захиргааны байгууллагад 11,699 өргөдөл гомдол, санал хүсэлт, талархал ирсний 11,605 өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн бөгөөд шийдвэрлэлт 99.2 хувийн үзүүлэлттэй байна. Шийдвэрлэх боломжгүй 11, хугацаа болоогүй 83 өргөдөл шийдвэрлэлтийн шатанд судлагдаж байна.

Аймгийн хэмжээний нийт төрийн захиргааны байгууллагад иргэдээс хандаж гаргасан өргөдлийг агуулгаар нь ангилахад Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт хандаж гарсан өргөдөл, хүсэлт зонхилж байна. Мөн тус онд өвөлжилт хүндэрсэнтэй холбоотой өвс, тэжээлийн дэмжлэг, малын сэг зэм устгах хүссэн хүсэлт 3,367 ирсэн нь нийт өргөдлийн 28.8 хувийг эзэлж байна.

2024 оны жилийн эцсийн байдлаар аймгийн Засаг даргад хандаж 140 өргөдөл, гомдол ирсний 100 өргөдөл нь бичгээр, 40 өргөдөл нь Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжин шилжиж ирсэн бөгөөд нийт өргөдлийн шийдвэрлэлт 95.7 хувийн үзүүлэлттэй байна. Ирүүлсэн өргөдөл, хүсэлтийг шийдвэрлэх хүрээнд 33 иргэнд 79,550,000 төгрөгийн эмчилгээний болон буцалтгүй тусламж, дэмжлэг олгосон. Аймгийн засаг даргад хандсан иргэдийн хүсэлтийн дагуу 4 өрхөд гэр олгосон.

Аймгийн нийт төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын төрлийг нэгдүгээр, өргөдлийн шийдвэрлэлтийг хоёрдугаар, нийт өргөдлийн агуулга болон зонхилж байгаа асуудлыг гуравдугаар хавсралтаар тус тус харуулав.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Аймгийн Засаг даргын орлогчийн  
2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн  
02/15 тоот албан бичгийн нэгдүгээр хавсралт

| Байгууллагын нэр | Өргөдөл гомдлын төрөл                                                                                             |                                                                                                                                                                         |                                                                                                                                 |                                                             | Хүлээн авсан хэлбэр                   |                               |                                                 |                                           |                                                |
|------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------|---------------------------------------|-------------------------------|-------------------------------------------------|-------------------------------------------|------------------------------------------------|
|                  | Мэдэгдэл                                                                                                          | Гомдол                                                                                                                                                                  | Санал                                                                                                                           | Хүсэлт                                                      | Биеэр                                 | Утсаар                        | Цахимаар                                        | 11-11 төвөөс шилжүүлсэн                   | Албан бичгээр                                  |
|                  | 1                                                                                                                 | 2                                                                                                                                                                       |                                                                                                                                 | 3                                                           | 4                                     | 5                             | 6                                               | 7                                         | 8                                              |
| Тайлбар:         | Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид заасан хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбогдон иргэдээс гарсан хүсэлт | Төрийн байгууллага албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан хүсэлт | Төрийн ба нутгийн удирдлагын байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулах, шинэчлэх талаар гаргасан иргэний хүсэлтийг | Байгууллагын дотоод асуудал, үйлчилгээ авах хүсэлтээс бусад | Иргэн өөрийн биеэр ирж, өргөдөл өгсөн | Байгууллагын тусгай дугаараар | Вэб сайт, аппликэйшн, сошиал флатформ, мэйл г.м | 11-11 төвд бүртгэгдэн, цахимаар шилжүүлэн | ААНБ, хуулийн этгээдээс албан бичгээр ирүүлсэн |
| Сүхбаатар        | 9                                                                                                                 | 49                                                                                                                                                                      | 102                                                                                                                             | 11539                                                       | 8833                                  | 752                           | 1532                                            | 55                                        | 527                                            |

-----oOo-----

Аймгийн Засаг даргын орлогчийн  
2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн  
02/15 тоот албан бичгийн хоёрдугаар хавсралт



| Шийдвэрлэлтийн байдал  |               |          |        |         |                                 |                                             |                                           |                                                                 |                  |                      |
|------------------------|---------------|----------|--------|---------|---------------------------------|---------------------------------------------|-------------------------------------------|-----------------------------------------------------------------|------------------|----------------------|
| Шийдвэрлэж хариу өгсөн |               |          |        |         | Бусад байгууллагад шилжүүлсэн   |                                             | Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн /30 хоног/ | Сунгалт хийсэн боловч хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн /60 хоног/ | Хугацаа болоогүй | Шийдвэрлэх боломжгүй |
| Аймгийн нэр            | Албан бичгээр | Цахимаар | Утсаар | Биечлэн | Харьяаллын дагуу шилжүүлсэн тоо | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн тоо |                                           |                                                                 |                  |                      |
| 0                      | 1             | 2        | 3      | 4       | 5                               | 6                                           | 7                                         | 8                                                               | 9                | 10                   |
| Сүхбаатар              | 1215          | 1642     | 777    | 7796    | 105                             | 55                                          | 5                                         | 10                                                              | 83               | 11                   |

-----oOo-----

Аймгийн Засаг даргын орлогчийн  
2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн  
02/15 тоот албан бичгийн гуравдугаар хавсралт

| №    | Гомдлын агуулга                                            | Тоо | Хувь | Өргөдөл гомдлыг бууруулахад цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал                                                                                                                                                                                                                                                                                              |
|------|------------------------------------------------------------|-----|------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1    | Худалдан авах ажиллагааны чиглэлээр                        | 6   | 0.06 | Оролцогч компаниудын ирүүлж буй Тендерийн баримт бичгийг чанартай болгох. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах.                                                                                                                                                                    |
| 2    | Эрүүл мэндийн чиглэлээр                                    | 18  | 0.15 | Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой гомдлыг бууруулах зорилгоор нарийн мэргэжлийн эмч нарыг үе шаттай давтан сургалтад хамруулах, эмнэлэг бүр эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой тохиолдлыг нэг бүрчлэн бүртгэж, дотоодын чанарын хяналтыг чангатгах, мөн эмч нарын орон тоог нэмэгдүүлж, хүний нөөцөөр хангах                                        |
| 3    | Газар олголт, өмчлөх, газрын дуудлага худалдааны чиглэлээр | 12  | 0.10 | Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд харилцаа хандлага, ёс зүйн сургалтыг тасралтгүй зохион байгуулах, ЭМГ-ын дэргэдэх эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороог шинэчлэн байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах                                                                                                                                               |
| 4    | Бусад                                                      | 13  | 0.11 | 2024 онд газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд шинэ суурьшлын бүс тогтоон дэд бүтцийг барьж иргэнд шинээр газар өмчлүүлэх саналыг Засгийн газарт хүргүүлсэн боловч хотын төлөвлөгөөгүй хийгдэж байгаа сумд болон Баруун-Урт сумын хувьд шинэ өмчлөлийн 105 газар нь гадна төлөвлөлт нь хийгдсэн үндэслэлээр шинэ өмчлөлийн газрууд хасагдаж батлагдсан. |
| Нийт |                                                            | 49  | 0.41 | Боловсролын байгууллага-1, Аймгийн цагдаагийн газарт-3, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газарт-3, Нийгмийн даатгалын газарт-2, бусад сумдад-4 Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөр ирсэн гомдол байгаа бөгөөд гомдлын хариуг хугацаанд нь шийдвэрлэж иргэн, аж ахуй нэгжид хариуг мэдэгдэж хамтран ажилласан.                                 |

-----oOo-----

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ  
ЗАРИМ АГЕНТЛАГ, СУМДЫН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТЭД  
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2025 оны 01 дүгээр сарын 06

Баруун-Урт сум

**НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ЗОРИЛГО**

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол шийдвэрлэх тухай” хууль, Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2007 оны 08 тоот албан даалгаврын дагуу аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудаас 2024 оны жилийн эцсийн байдлаар ирүүлсэн иргэдийн өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн байдал, иргэнд хариу мэдэгдсэн байдалд дүгнэлт гаргаж, холбогдох албан тушаалтанд бодит мэдээлэл өгсний үндсэн дээр цаашдын төлөвлөлтийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

**ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

Сүхбаатар аймгийн төрийн байгууллага албан тушаалтнаас төрийн үйлчилгээ авсан иргэдийн эрх ашгийг зөрчсөн гэж үзэж хуулиар хамгаалагдсан эрх чөлөө, ашиг сонирхлоо сэргээлгэхээр гомдол, санал гаргасан хүсэлтийг салбар, байгууллага, албан тушаалтан бүрээр нарийвчлан гаргасан мэдээнд үндэслэн дээрх сум, байгууллагыг сонгон авсан болно.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийхдээ тухайн сонгон авсан агентлаг, сумдын нийт өргөдлийн бүртгэл, ангилалт, 2024 оны өргөдөл гомдлын тайлан, мэдээг авч дүн шинжилгээ хийсэн ба гаргасан гомдлуудыг хэрхэн шийдвэрлэсэн талаар анхаарч ажиллалаа.

2024 оны жилийн эцсийн байдлаар аймгийн Засаг даргад хандаж 140 өргөдөл, гомдол ирсний 100 өргөдөл нь бичгээр, 40 өргөдөл нь Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжин шилжиж ирсэн бөгөөд нийт өргөдлийн шийдвэрлэлт 95,7 хувийн үзүүлэлттэй байна. Ирүүлсэн өргөдөл, хүсэлтийг шийдвэрлэх хүрээнд 33 иргэнд 79,550,000 төгрөгийн эмчилгээний болон буцалтгүй тусламж, дэмжлэг олгосон. Аймгийн засаг даргад хандсан иргэдийн хүсэлтийн дагуу 4 өрхөд гэр олгосон.

Хүсэлт, мэдэгдлийн шинжтэй гомдлууд байгууллагын хэмжээнд хуулийн хугацаанд бүрэн шийдэгдсэн байна.

**ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ  
/Сум, агентлаг тус бүрээр/**

**1. Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар:**  
Өргөдөл, гомдол ирүүлсэн байдлын мэдээ:

| Хүсэлт | Мэдэгдэл | Санал | Гомдол                                         | Талархал | Нийт<br>Өргөдөл |
|--------|----------|-------|------------------------------------------------|----------|-----------------|
|        |          |       | Байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой |          |                 |
| 1      | 2        | 3     | 4                                              | 5        | 6               |
| 1167   | 0        | 0     | 12                                             | 0        | 1179            |

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт хандан гаргасан нийт 12 иргэний 6 иргэний гомдолд хариу өгсөн байдлыг судлахаар холбогдоход гомдлын хариугаа авсан хэдий ч тавьсан асуудлаа бүрэн шийдвэрлүүлээгүй гэсэн 2, бүрэн шийдвэрлүүлсэн гэсэн 1 иргэн байна. 3 иргэний утас нь холбогдохгүй байсан.

Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар нь жилийн эцсийн байдлаар нийт 1179 өргөдөл ирсний цахимаар 978, биечлэн 201 иргэнд хариу өгсөн байна. Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжин 7 гомдол ирсэн байна.

Тус газар нь гомдлыг шийдвэрлэхдээ Газрын тухай хууль болон холбогдох хууль журмыг үндэслэн хариуг өгсөн байна.

Газрын харилцаа барилга хот байгуулалтын газарт ирсэн 12 гомдлын дийлэнх хувийг ажилтан, албан хаагчдын харилцаа, газрын дуудлага худалдаа, газар өмчлөх, эзэмших эрх шилжүүлэх, газар хүсэх зэрэг асуудлууд эзэлж байна.

Ирүүлсэн нийт гомдлын агуулгыг авч үзвэл шинээр газар өмчилж авахыг хүссэн өргөдөл хүлээж авахгүй газар олгохгүй байгаа талаар, газрын дуудлага худалдааны талаар, давхардуулан газар олгосон талаар гомдлууд ирсэн байна. 2024 онд газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд шинэ суурьшлын бүс тогтоон дэд бүтцийг барьж иргэнд шинээр газар өмчлүүлэх саналыг Засгийн газарт хүргүүлсэн боловч хотын төлөвлөгөөгүй хийгдэж байгаа сумд болон Баруун-Урт сумын хувьд шинэ өмчлөлийн 105 газар нь гадна төлөвлөлт нь хийгдсэн үндэслэлээр шинэ өмчлөлийн газрууд хасагдаж батлагдсан байна.

**2. Боловсрол, шинжлэх ухааны газар:**

Өргөдөл гомдлын мэдээ:

| Хүсэлт | Мэдэгдэл | Санал | Гомдол | Талархал | Нийт<br>Өргөдөл |
|--------|----------|-------|--------|----------|-----------------|
|        |          |       |        |          |                 |
| 1      | 2        | 3     | 4      | 5        | 6               |
| 475    | 0        | 0     | 1      |          | 476             |

Боловсрол, шинжлэх ухааны газарт хандан гаргасан 1 иргэний гомдлыг судлахад иргэн Б.Хонгор нь Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Ерөнхий боловсролын сургуульд Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжуулан 2024 оны 07 дугаар сарын 30-ны өдөр гомдол гаргасан байна. Тус иргэнтэй холбогдоход гомдлын хариуг 08 дугаар сарын 09-ний өдөр хүлээн авсан, Эрдэнэцагаан сумын ЕБСургуульд 2023 оны 09 дүгээр сарын 01-ээс 12 дугаар сарын 08-ны өдрийг хүртэл ажилласан бөгөөд Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.2 дахь заалтыг хангаагүй тул ээлжийн амралт олгох боломжгүй гэсэн хариуг мэдэгдсэн байна.

**3. Байгаль орчин, аялал жуулчлалын газар:**

Өргөдөл гомдлын мэдээ:

| Хүсэлт | Мэдэгдэл | Санал | Гомдол | Талархал | Нийт<br>Өргөдөл |
|--------|----------|-------|--------|----------|-----------------|
| 1      | 2        | 3     | 4      | 5        | 6               |
| 50     | 0        | 0     | 0      | 0        | 50              |

Байгаль орчин, аялал жуулчлалын газарт хандан нийт 50 өргөдөл гаргаснаас гомдлын шинжтэй 4 өргөдөл ирсэн байна.

Тус газарт ирж буй нийт өргөдлийн дийлэнх хувийг БОНБҮГ хүссэн өргөдөл эзэлж байна. Гомдол 100 хувь шийдвэрлэгдсэн байна.

Санал, мэдэгдлийн шинжтэй асуудал иргэдээс тавиагүй байна.

### СУМДЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

#### 1. Баруун-Урт сум:

| Хүсэлт | Мэдэгдэл | Санал | Гомдол | Талархал | Нийт<br>Өргөдөл |
|--------|----------|-------|--------|----------|-----------------|
| 1      | 2        | 3     | 4      | 5        | 6               |
| 5704   | 0        | 0     | 2      | 0        | 5706            |

Баруун-Урт сумын Засаг даргын Тамгын газарт хандан гаргасан нийт 5706 өргөдөл гаргаснаас гомдлын шинжтэй 2 өргөдөл байна.

Тус онд Сүхбаатар аймгийн хэмжээнд өвөлжилтийн байдал хүндэрсэнтэй холбоотойгоор Баруун-Урт сумын Засаг даргын тамгын газарт ирж буй нийт өргөдлийн 3017 өргөдөл нь өвс, тэжээлийн дэмжлэг хүсэх буюу нийт өргөдлийн 47,1% эзэлж байна. Мөн отрын штаб байгуулах, малын сэг зэмийн устгал, зам гаргах, цасанд дарагдсан, нүүрс түлээ олгох зэрэг иргэдийн хүсэлт ихэнх хувийг эзэлсэн байна. Баруун-Урт сумын ЗДТГазраас иргэдээс ирсэн хүсэлтийг аймгийн Онцгой байдлын газар, Цагдаагийн газар болон эмнэлгийн тусламж үйлчилгээтэй хамтран бүх иргэдийн хүсэлтийг хуулийн хугацаанд хариу өгч эргэх холбоотой хамтран ажиллаж шийдвэрлэсэн.

Санал, мэдэгдлийн шинжтэй асуудал иргэдээс тавиагүй байна.

#### 2. Асгат сум:

| Хүсэлт | Мэдэгдэл | Санал | Гомдол | Талархал | Нийт<br>Өргөдөл |
|--------|----------|-------|--------|----------|-----------------|
| 1      | 2        | 3     | 4      | 5        | 6               |
| 10     | 0        | 0     | 0      | 0        | 102             |

Асгат сумын Засаг даргын Тамгын газарт хандан гаргасан нийт 102 өргөдөл гаргаснаас гомдлын шинжтэй өргөдөл гаргаагүй байна. Нийт гаргасан өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн бөгөөд шийдвэрлэлт 100 хувийн үзүүлэлттэй байна. Сумын хэмжээний нийт төрийн захиргааны байгууллагад иргэдээс хандаж гаргасан өргөдлийг агуулгаар нь ангилахад Газрын даамалд гаргасан өргөдөл зонхилж байна.

#### 3. Сүхбаатар сум:

| Хүсэлт | Мэдэгдэл | Санал | Гомдол | Талархал | Нийт<br>Өргөдөл |
|--------|----------|-------|--------|----------|-----------------|
| 1      | 2        | 3     | 4      | 5        | 6               |
| 235    | 0        | 0     | 0      | 0        | 235             |

Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газарт хандан гаргасан нийт 235 өргөдөл гаргаснаас гомдлын шинжтэй өргөдөл байхгүй. Сумын хэмжээний нийт төрийн захиргааны байгууллагад иргэдээс хандаж гаргасан өргөдлийг агуулгаар нь

ангилахад хүний нөөцтэй холбоотой 2 байгаа бөгөөд Засаг даргын тамгын газрын даргын сул орон тоо зарлагдаж Л.Цэгмэд тусгай шалгалтад орж тэнцээд 2024 оны 12 дугаар сарын 2-ний өдрийн Б/46 дугаар захирамжаар томилогдон ажиллаж байна. Мөн Архив бичиг хэргийн эрхлэгч өөр байгууллага руу шилжих хүсэлт гаргаж хүсэлтийн дагуу шийдвэрлэсэн. Газар эзэмших, шилжүүлэх, газрын хэмжээ өөрчлөгдсөн, дуудлага худалдаанд оролцох, Малчдын хоршооны газар гэх мэт газрын үйл ажиллагаатай холбоотой нийт 233 хүсэлт, өргөдөл ирсэн. Үүнээс цахимаар шийдвэрлэсэн-31, Албан бичгээр шийдвэрлэсэн-159, Биечлэн уулзаж-35, шийдвэрлэх хугацаа болоогүй 9 өргөдөл байна. Иргэдийн Өргөдлийг хүлээн авч зохих хууль ёсны дагуу Захирамжаар шийдвэрлэж холбогдох хурлаар хэлэлцэж Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган ажиллаж байна. Саналын шинжтэй асуудал иргэдээс тавиагүй байна.

### **ДӨРӨВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮГНЭЛТ**

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандан гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлаг, сумдын Засаг даргын Тамгын газарт хандан гаргасан өргөдөл, гомдол шийдвэрлэлтэд хяналт-шинжилгээ хийхэд дараах нийтлэг зөрчил, дутагдал илэрлээ. Үүнд:

1. Агентлаг, сумдын Засаг даргын Тамгын газар өргөдөл, гомдлыг хуулийн дагуу ангилахдаа алдаатай бүртгэж байна. /Мэдэгдэл, хүсэлт, санал/

2. Засгийн газрын 11-11 төвөөр дамжуулан иргэдээс гаргасан гомдлууд зарим тохиолдолд тухайн байгууллагын бүрэн эрхэд хамаарахгүй, дангаар шийдвэрлэх боломжгүй, өөр хүний нэрээр явуулсан байна.

### **ТАВ. ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ:**

-Аймгийн ЗДТГ, сум, агентлаг байгууллагуудаас иргэний өргөдөл гомдлыг шийдвэрлэж буй байдал, иргэний сэтгэл ханамжийн байдалд ажлын хэсэг гарган улирал бүр дүн шинжилгээ хийж холбогдох байгууллага, албан тушаалтанд хариуцлага тооцох, үүрэг чиглэл, зөвлөмж өгөн ажиллах;

-Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хүрээнд төрийн албан хаагчтай холбоотой ёс зүйн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд анхаарч түүнийг арилгах чиглэлээр зөвлөмж чиглэл өгч Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зэрэг болно.

ТАЙЛАН ХЯНАСАН:  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ  
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Н.МӨНХГЭРЭЛ

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:  
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Б.БЯМБАСҮРЭН